

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Худалдаа, хөгжлийн банк болон Ти Ди Капитал ХХК нарын хооронд байгуулсан 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн №ЗГ9101/181218 тоот “Зээлийн гэрээ”-ний нөхцөлд өөрчлөлт оруулж, Ти Ди Капитал ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй “Зээлийн нэмэлт гэрээ”-г байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Худалдаа, хөгжлийн банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захиран (О.Орхон)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОПКА

Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зовлолийн
2023 оны 12 дугаар сарын **06**-ны өдрийн **69** тоот тогтоолын хавсралт

Зээлийн нэмэлт гэрээний нөхцөл

Гэрээний иэр	Өөрчлөлт орсон нөхцөл
Зээлийн нэмэлт гэрээ	Зээлийн хугацаа: 72 сар (энэ хугацаа нь 2018 оны 12-р сарын 18-ны өдрөөс эхлэн тооцогдоно.)